



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/126

Улаанбаатар хот

Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас бэлтгэн нийлүүлсэн 191,979,800.0 (нэг зуун ерэн нэгэн сая есөн зуун далан есөн мянга найман зуу) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор (С.Амгалан)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор (С.Амгалан)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн ДИУБ-дугаар тушаалын хавсралт

БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Байгууллагын нэр: Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлд авах		Эх үүсвэрээр		
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр	
1	Компьютер	Dell	Core TM7	2025	шинэ	ш	38	4,907,700.00	186,492,600.00	НЗДТГ	хандив	
2	Принтер	HP	3 үйлдэлтэй	2025	шинэ	ш	3	1,229,400.00	3,688,200.00			
3	Принтер	Epson	4 үйлдэлтэй	2025	шинэ	ш	1	1,799,000.00	1,799,000.00			
	Машин тоног төхөөрөмжийн дүн							1		191,979,800.00		
	Нийт бүртгэх хөрөнгийг дүн							2		191,979,800.00		